



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ  
“СУДАЛГАА, ХӨГЖИЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТӨВ”



3-Р УЛИРЛЫН БАЙДЛААР  
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 ОН

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гүйцэтгэсэн судалгааны ажлууд.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зураг 2. Утааны тортогжилт багасгах төслийн семинар.....	4
Зураг 3. ААНБ-ын үйл ажиллагаатай танилцах явц .....	5
Зураг 4. ОХУ-д хүнд даацын автомашинд хийн тоног төхөөрөмж суурилуулсан байдал .....	6
Зураг 5. Тээврийн хэрэгсэлд хүн суулгаж буй байдал.....	7
Зураг 6. Сургалтад хамрагдаж буй байдал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зураг 7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт.....	8
Зураг 8. Судалгааны мэргэжилтнүүдийн үйлчлүүлэгчдээс судалгаа авч буй үйл явц .....	9
Зураг 9. Үйлчлүүлэгчтэй утсаар холбогдож буй явц.....	10
Зураг 10. Үйлчилгээний стандартын биелэлт .....	11
Зураг 11. Цахилгаан болон хийгээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгааны ажлын биелэлт .....	12

### **3-Р УЛИРЛЫН БАЙДЛААР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД**

#### **1.1 Автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийн судалгаа**

Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар болон гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хүрээнд агаарын бохирдлын 10 хувийг дангаар эзэлж буй автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг бууруулах чиглэлээр автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийн судалгааг үе шаттайгаар хийж гүйцэтгэв. Энэхүү ажлын зорилго нь бензин болон дизель хөдөлгүүртэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломжийг тодорхойлох юм.

#### Судалгааны ажлын хүрээнд:

Судалгааны ажлыг Автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн сан, Техникийн хяналтын хэлтэс, Статистик мэдээллийн нэгдсэн сан, БНХАУ, БНСАУ, Япон улсын туршлагыг хамрах хүрээ болгон ажилласан.



- ✓ Судлагдсан байдлын тойм бэлтгэх: Тоймыг дараах 6 хэсэгт хуваан авч үзлээ. Үүнд: 1. “Улаанбаатар хотод автомашин ашиглалтын экологийн сөрөг үр дагаварын судалгаа” (1998-2000 он)
- 2. “Тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулах арга замууд” (2006 он)
- 3. “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх” төсөл 1-р үе шат (2010-2013 он)
- 4. “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” 2-р үе шат (2013-2017 он)

✓ Автотээврийн хэрэгслээс ялгарах утаа нь агаар, орчинд үзүүлж буй нөлөөллийн судалгааг хийх: Агаарын бохирдол болон түүний төрөл, агаар бохирдуулах бодис түүний шинж чанар, агаарын бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх үзүүлэлтийг тодорхойлсон бөгөөд Улаанбаатар хотын агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө судалгаа, Дэлхийн агаарын чанарын тайлангуудыг авч ашигласан.

✓ Монгол улсын автопаркын өнөөгийн байдлын судалгаа: Монгол улсын автопаркад ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо, төрөл, насжилт, шатахууны төрөл, хөдөлгүүрийн багтаамж тус бүрээр судалгааг гаргасан. Мөн нефтийн бүтээгдэхүүний импорт, Евро стандартын шатахуун, Автотээврийн хэрэгсэлийн утаа шүүгч түүний төрөл ангилал, Олон улсад автомашины хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт бодисын хэмжээнд тавигдах стандарт, шаардлагын судалгааг хийж, олон хүчин зүйлт корреляцын шинжилгээг хийсэн.

✓ Монгол улс ба олон улсын эрх зүйн баримт бичгийн судалгаа: Монгол улсын хууль, Тээврийн хэрэгслийн салбарын дүрмийг зохицуулах бүх дэлхийн форум (WP29)-ын зохицуулалтаас шүүн гаргахад WP29-н “M, N, O, Трактор, Механизм”

төрөл ангилалд тээврийн хэрэгслийн утааны зохицуулалттай холбоотой 5 шаардлага байдаг байна.

✓ Бусад орны тэргүүн туршлагыг судлах: Уг судалгаагаар Япон, БНСУ болон Ceracomb Co., Ltd шүүлтүүр үйлдвэрлэгч компани, БНХАУ болон Wuxi Wefu Environmental Catalysts Co., Ltd, Xiangtan weida electrical and machinery manufacture Co.,Ltd компаниудын утааны шүүлтүүрийн үйлдвэрлэл нэр төрөл, тоног төхөөрөмж, зохион байгуулалт, патентийн судалгааг хийсэн.

✓ Монгол улсад утаа шүүгч үйлдвэрлэхэд шаардагдах түүхий эд, материалын судалгаа /ТЭЗҮ/: Зах зээлийн шинжилгээ, Бүтээгдэхүүн үйлчилгээ, техник технологийн шийдэл, Утаа шүүгч үйлдвэрлэхэд шаардагдах тоног, төхөөрөмжийн судалгаа, Утааны шүүлтүүр үйлдвэрлэхтэй холбоотой патентын судалгаа, Утаа шүүгч үйлдвэрлэхэд



шаардагдах түүхий эд, материалын судалгаа, Үйлдвэр байгуулах барилга, байгууламж дэд бүтцийн төлөвлөлт, Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг статистик шинжилгээ, чанарын шинжилгээ хийж тайланд тусгасан.

✓ Эхний шатны тайланг 1/239 тоот албан бичгээр ЗТХТөвд хүргүүлсэн байна.

✓ Эцсийн шатны тайланг 06.15-нд ЗТХТөвд хүргүүлэв.

✓ Нийтийн тээвэрт явж байгаа тээврийн хэрэгслийн утааны тортогжилт багасгах төслийн семинарт хамрагдсан.

*Зураг 1. Утааны тортогжилт багасгах төслийн семинар*



## **1.2 Гашуун сухайт боомтын чиглэлд ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгсэлд байгаль орчинд ээлтэй технологи суурилуулах боломж**


Өмнөговь аймгийн Ханбогд сумаас “Гашуун сухайт” боомт хүртэлх 130 км замын чиглэлд Байгалийн шингэрүүлсэн хийн станц байгуулах боломж, хүнд даацын /зүтгүүр/ автомашины хөдөлгүүрийг хийн түлшээр ажиллуулах боломжийн талаар судлах ЗОРИЛГООР энэхүү судалгааг хийв.

## Судалгааны ажлын хүрээнд:

Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 6278:2011, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009 стандарт, “Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS 5345:2011 зэрэг хууль эрх зүйн орчинг судалсан. Мөн Судалгааны ажлын хүрээнд хүнд даацын /зүтгүүр/ автомашины дизель хөдөлгүүрийг метан түлшээр ажиллуулах боломжийг судлахын тулд нүүрс тээвэрт голчлон тээвэрлэлт гүйцэтгэж буй “North Benz” автомашиныг сонгон авч дараах ААНБ-ын үйл ажиллагаатай танилцан судалгааг ярилцлага болон ажиглалтын аргаар судалгаагаа явуулсан. Үүнд:

- ❖ “Эрдэм Транс” ХХК
- ❖ “ММК” ХХК буюу БНХАУ-ын “BEIBEN TRUCK” компаний албан ёсны төлөөлөгчийн газар
- ❖ “FOTON CENTER” худалдаа үйлчилгээний төв

*Зураг 2. ААНБ-ын үйл ажиллагаатай танилцах явц*



Дизель хөдөлгүүртэй хүнд даацын /зүтгүүр/ автомашиныг метан хийн түлш /хосолсон хөдөлгүүр/-тэй болгох боломжийг эдийн засаг болон нийгмийн ач холбогдлын талаас судлан судалгаанд дараах асуудлыудыг дэлгэрэнгүй тусгасан. Үүнд:

- Дизель хөдөлгүүртэй хүнд даацын автомашины өнөөгийн байдал
- Хүнд даацын автомашинд хийн түлшний тоног төхөөрөмж суурилуулснаар гарах нийгмийн ач холбогдол
- Хүнд даацын автомашинд хийн түлшний тоног төхөөрөмж суурилуулснаар гарах эдийн засгийн ач холбогдол
- МУ-д хүнд даацын автомашины дизель хөдөлгүүрийг газан хосолсон хөдөлгүүртэй болгосон туршлага
- Америкийн нэгдсэн улсын EPA буюу Байгаль орчныг хамгаалах нэгдсэн агентлагаас “Хүнд даацын автомашин”-ны яндангаас ялгарах хорт утааны норм
- ОХУ-ын туршлага

Зураг 3. ОХУ-д хүнд даацын автомашинд хийн тоног төхөөрөмж суурилуулсан байдал



Өмнөговь аймгийн нутаг давсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудаас ялгарч байгаа метан хийг цуглуулан, шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх, цаашдаа “ГАНУУН СУХАЙТ” боомтод нүүрс тээвэрлэлт гүйцэтгэж байгаа **18771** хүнд даацын /зүтгүүр/ автомашины дизель хөдөлгүүрийг газан /хосолсон/ хөдөлгүүрээр ажиллуулах боломжийн талаар судаллаа.

Судалгааны эхний ээлжийн дүгнэлтээр Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын чиглэлд тээвэрлэлт гүйцэтгэж байгаа том оврын ачааны машины 65% -аас дээш 5-аас дээш жилийн насжилттай. Хэрэв одоо тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн дизель хөдөлгүүрийг сольж газан хөдөлгүүр болгон, эд ангийг өөрчлөхөд аюулгүй байдал талаасаа болон техникийн талаасаа боломж байхгүй гэж үзэж байна.

Оюутолгой ХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалт дуусч, нүүрс олборлож эхэлвэл агааржуулалтын цооногоос гадагшлах хийн 90 орчим хувь нь цэвэр метан хий байна. Энэ гадагшилж байгаа хийг савлан шингэрүүлсэн түлш болгон үйлдвэрлэж чадвал шингэрүүлсэн шатдаг хийн үнэ даруй 3-4 дахин хямдарч, газан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийг импортоор оруулж ирж тээвэрлэлт хийхэд нүүрс тээвэрлэлтын зардал 2 дахин буурах боломжтой нь харагдаж байна.

### **1.3 Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах**

“Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн математик загварчлал боловсруулах” судалгааны ажил нь төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд судалгааны мэргэжилтэн Б.Тунгалагтамир болон ахлах мэргэжилтэн Ц.Оюунсүрэн нар хариуцан гүйцэтгэхээр тусгагдсан. Хот хоорондын зорчигчдыг татах хүчин зүйлс, газар зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан зорчигчдын тархалтыг урьдчилан таамаглах математик загварчлалыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

#### **Судалгааны ажлын хүрээнд:**

Судалгааны ажлын мэдээ мэдээллийг бодит болон цахим орчноос цуглуулсан. Тухайлбал цахим орчноос бусад орны хот хоорондын зорчигч тээврийг төлөвлөх математик загвар, хууль бус тээвэрлэлтийг зохицуулж буй үйл ажиллагаа, хууль эрх зүй зэрэг мэдээллийг, хууль бус тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн мэдээлэл болон түүгээр үйлчлүүлэгчээс асуулга асуух зэргээр хот хооронд хууль бус тээвэрлэлтийн мэдээллийг бодит орчноос цуглуулсан.

Зураг 4. Тээврийн хэрэгсэлд хүн суулгаж буй байдал



Мөн Зорчигч тээврийн тасаг, Хөдөлгөөн удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдтэй уулзаж судалгааны ажлын зорилгыг танилцуулан, судалгааны ажилд хэрэгтэй хот хоорондын зорчигч тээврийн дата мэдээлэл болон хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалт, зохицуулалтын тоон мэдээллийг ирүүлэхийг санал болгосон ба дотоод сүлжээгээр хүлээн авсан. Эдгээр мэдээлэлд дараах дүн шинжилгээ, боловсруулалтыг хийсэн. Үүнд:

Чанарын шинжилгээ:

Автотээврийн тухай хууль болон бусад холбогдол бүхий нийт 5 баримт бичигт хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагааг зохицуулж буй зүйл заалтыг тодруулах замаар чанарын шинжилгээг хийж судалгааны ажилд үндэслэл болохуйц зүйл заалтыг тодруулан судалгааны ажлын “Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн хууль эрх зүйн орчин” бүлэгт тусгасан.

Мөн олон улсын хот хоорондын тээвэр төлөвлөлтийн арга аргачлалыг “Planning and Operational Analyses for A New Intercity Transit Service”, “Investigation of approaches to modeling of intercity passenger transportation system” зэрэг баримт бичиг болон бусад мэдээ мэдээллийг үндэслэн “Олон улсын туршлага” бүлгийг боловсруулсан.

Статистик шинжилгээ:

Зорчигч тээврийн үйлчилгээний бүртгэлийн систем болон бусад эх үүсвэрээс цуглуулсан дата мэдээллийг эмхэлж хийж шинжилгээнд шаардлагатай өгөгдлүүдийг түүвэрлэн файл үүсгэсэн. Энэхүү өгөгдөлд Microsoft Excel програмын Data/analysis цэсний тусламжтайгаар дүрслэх-тодорхойлох статистик шинжилгээг хийж үр дүнг график, хүснэгтээр илэрхийлж “Хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтийн өнөөгийн байдал” бүлгийг боловсруулсан. Мөн хот хоорондын зорчигч тээвэр төлөвлөлтөд тусгагдсан чухал үзүүлэлтүүдийг өөрийн судалсан онол арга зүйд буюу математик аргачлалаар тооцоолыг хийж үр дүнг гарган санал зөвлөмж хүргүүлсэн.

Судалгааны ажлын үр дүн:

Судалгааны ажлын үр дүнд “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм”-ийн 3.3.4-д зорчигч тээврийн тухайн чиглэлд тээвэрлэлтийн эрэлт зайлшгүй нэмэгдэн суудал ашиглалтын коэффициентийн дундаж 0.90-ээс доош тохиолдолд цагийн давтамж нэмэгдүүлэхгүй хэмээн тусгасанг энэхүү үзүүлэлтийг (суудал ашиглалтын коэффициент) чухалчилж үзсэн. Тиймээс суудал ашиглалтын коэффициентийг динамик аргаар тооцоолох нь автобус дүүргэлтийн мэдээллийг


бүрэн харуулах, дүрмийн хэрэгжилтийг хангахуйц үзүүлэлтийг тодорхойлж чадна хэмээн үзэж энэхүү аргаар тооцооцох зөвлөмжийг хүргүүлсэн. Мөн хот хоорондын зорчигч тээврээр үйлчлүүлж буй зорчигч урсгалын хэмжээг нэмэгдүүлэх үүднээс хууль бус тээвэрлэлтийн эсрэг авах арга хэмжээний талаар зөвлөмж 2-д тусган тайланг боловсруулсан.

## 2.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн:

Үйлдвэрийн газрын удирдлагаас болон нэгжийн даргаас нийт 5 ажил үйлчилгээг гүйцэтгэх үүрэг даалгавар өгсөн. Үүнд:

- Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа
- Техникийн хяналтын үзлэгийн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Үйлдвэрийн газрын “Үйлчилгээний стандарт” боловсруулах
- Автотээврийн салбарын судалгаа, эрдэм шинжилгээний чиг үүргийг чадавхжуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл
- Цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгаа

Зураг 5. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт



Судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг дараах хэсэгт тус бүрээр дэлгэрэнгүй тусгалаа

### 2.1.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа:

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай байгуулсан контактын гэрээний биелэлтийг хангуулах зорилгоор 2017 оноос хойш үйлдвэрийн газрын ажилтан болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жилд 1 удаа авч байна. Судалгааны ажил нь “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ажил үйлчилгээг авч буй



үйлчлүүлэгч болон үйлдвэрийн газрын ажилтан албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах зорилготой.

Судалгааны ажлын хүрээнд:

Энэхүү ажлын хүрээнд Тээврийн хэрэгслийн төв, Техникийн хяналтын төвүүд, Зорчигч үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс асуулгын дагуу анкетын аргаар судалгаа авсан бөгөөд нийт 350 үйлчлүүлэгч хамруулсан.

*Зураг 6. Судалгааны мэргэжилтнүүдийн үйлчлүүлэгчдээс судалгаа авч буй үйл явц*



Үйлдвэрийн газрын ажилтнуудаас асуулгын дагуу судалгааг цахим хэлбэрээр буюу дотоод сүлжээнд линк байрлуулах байдлаар нийт 336 ажилтанг хамруулсан.

Судалгааны үр дүн:

Сэтгэл ханамжийн үнэлгээ, ач холбогдлын түвшин гэсэн хоёр бүлэг асуумжийн хүрээнд сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон бөгөөд олон улсын **ServQual** аргыг ашиглан тооцсон бөгөөд дараах үр дүн гарсан.

Судалгаанд хамрагдсан ажилчид үйлдвэрийн газрын захирлын удирдах арга барил, ур чадварт нь 249 ажилтан буюу 74% нь сайн, үлгэр дууриалал манлайлалд 235 ажилтан буюу 70% нь сайн, заавар зөвлөгөө өгөх, сонсох ур чадварт дийлэнх хувь буюу 73% сайн гэсэн үнэлгээ өгсөн мөн нийт үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн индекс дундаас дээгүүр (7.26-8.08) байна. Иймд бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа бус тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой ажил сайжруулах төлөвлөгөө гарган үйлчилгээний чанарыг байнга сайжруулж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт бүхий тайланг боловсруулсан. Үр дүнг үйлдвэрийн газрын удирдлагууд болон холбогдох төвүүдийн дарга нарт танилцуулж, тайланг хүргүүлсэн.


### **2.1.2. Техникийн хяналтын үзлэгийн төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа**

Техникийн хяналтын үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох, судалгааны мэдээлэл цуглуулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

#### Судалгааны ажлын хүрээнд:

Судалгааг 25 хэмжигдэхүүн бүхий тоон судалгааны аргаар тусгайлан боловсруулсан асуумжаар утсаар холбогдон судалгааны мэдээллийг цуглуулсан болно. Судалгааны асуулгад 16 асуулгыг нээлттэй, 9 асуулгыг хаалттай бөглөхөөр асуулгийг бэлтгэсэн. Мөн Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх техникийн хяналтын төвөөр үйлчлүүлсэн нийт 180 үйлчлүүлэгчээс утсаар холбогдож асуулгын дагуу судалгаа авч үр дүнгийн тайлан боловсруулсан.

*Зураг 7. Үйлчлүүлэгчтэй утсаар холбогдож буй явц*



#### Судалгааны үр дүн:

Асуулгын үр дүн, үйлчлүүлэгчээс ирүүлсэн санал, хүсэлтийг нэгтгэн судалгааны 29 хуудас бүхий тайлан боловсруулж нэгжийн дарга, техникийн хяналтын төвүүдийн дарга болон бусад холбогдох ажилтан албан хаагчид танилцуулж, захидлаар хүргүүлсэн.

### **2.1.3. Үйлдвэрийн газрын “Үйлчилгээний стандарт” боловсруулах ажлын хүрээнд**

Үйлчилгээний стандарт нь үйлдвэрийн газраас үзүүлж буй үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд зөв боловсон, хурдан шуурхай, шударга, тэгш хүртээмжтэй, чанартай хүргэх зорилготой. Стандарт нь удиртгал, ажилтны үйлчилгээний зарчим, үйлчилгээний нийтлэг шаардлага, үйлчилгээний үед хориглох үйлдлүүд, хяналт хариуцлага урамшуулал гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

#### Судалгааны ажлын хүрээнд:


Үйлдвэрийн газарт хэрэгжиж байгаа дүрэм, журам мөн төрийн үйлчилгээний ижил төстэй байгууллагуудын үйлчилгээний стандартуудыг уншиж танилцан стандартын төслийг боловсруулж, төслийг төвийн ажилтнууддаа танилцуулан санал авч нэгтгэсэн. Төвийн ахлах мэргэжилтэн А.Батчулуун болон төвийн дарга Н.Зоригоор хянуулсны дараа дотоод сүлжээгээр нийт бүтцийн нэгжүүдэд санал ирүүлэх тухай мэдэгдсэн. Дэд захирал Ц.Эрдэнэчулуун, Хөдөлгөөний удирдлагын

хэлтэс, Зорчигч тээврийн хэлтэс, Увс, Өмнөговь аймгийн автотээврийн төв, Замын-Үүд салбараас санал ирүүлснийг нэгтгэн ажиллалаа.

### Судалгааны ажлын үр дүн:

“Үйлчилгээний стандарт”-ын төслийг нэгтгэн танилцуулж захирлын 2022.06.08-ны өдрийн А/148 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд хэрэгжилтийг “Захиргаа сургалт хүний нөөцийн хэлтэс”-д хангаж ажлах чиглэл өгсөн.

### Зураг 8. Үйлчилгээний стандартын биелэлт



### **2.1.4. “Автотээврийн салбарын судалгаа, эрдэм шинжилгээний чиг үүргийг чадавхжуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл” судалгааны ажил**

Ижил төстэй судалгааны байгууллага, төслийн менежментийн сургалтын гарын авлага (зүүн ба зүүн хойд азийн бүс нутгийн холбогдох чадварыг бэхжүүлэхэд чглэсэн сургалт), үндэсний хөгжлийн газрын даргын тушаалаар батлагдсан Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал болон төсөл хэрхэн бичих талаар судалж танилцан төслийг боловсруулж эхэлж байна.

### **2.1.5. Цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгаа авах**

ЗТХЯ-ны 2022.05.24-ний өдрийн 07/2351 тоот албан бичигт дурдсаны дагуу судалгааны маягт боловсруулж 21 аймгийн автотээврийн төвийн дарга, ахлах нягтлан бодогч, автотээврийн хяналтын мэргэжилтэн нарт ERP сүлжээний захидлаар илгээсэн. Мөн аймгийн АТТ-ийн дарга нартай утсаар холбогдож судалгаа ирүүлэх тухай болон судалгаанд анхаарах зүйлсийн талаарх зөвлөгөөг нэмэлтээр өгсөн.

### Судалгааны ажлын үр дүн:

Аймгийн АТТ-өөс ирүүлсэн цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгааг нэгтгэсэн. Судалгаагаар 21 аймагт хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх 79 байгууламж, цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх байгууламж Хэнтий аймагт – 1, Өмнөговь аймагт – 2 байгааг объектийн зураг, цэнэглэх хошуу зэрэг мэдээллийн хамт гарган 2022.06.10-

ны 1/789 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. Мөн судалгааны файлыг АТБХЗГ-ын мэргэжилтэн Хабидолдагийн [khavi0770@gmail.com](mailto:khavi0770@gmail.com) цахим хаягаар хүргүүлсэн.

**Зураг 9. Цахилгаан болон хийгээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгааны ажлын биелэлт**

Д/д	Үйлчлэх үзүүлэлт буюу ААН Байгууллагын нэр	Хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн байршил	Объектын зураг	Цэнэглэгчийн тоо	Аймгийн үрт болон дунд нутгааны нэгжид бодлогын баримт бичигт тусгагдсан ирээдүйн төлөвлөгөөт
<b>Архангай аймаг</b>					
1	Дашванжилт Бутган хангай газ	5-р бүлгийн Бутган хангай хороолол		2 хошуутай 1 тусгагч	Санаг тусгагдаагүй байна
2	Дашванжилт Хорго газ	Тарнат сум Хорго баг		2 хошуутай 1 тусгагч	
<b>Баян-Өлгий аймаг</b>					
					


**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**  
**ТӨРИЙН ОМЧИГ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**  
 14251 Улаанбаатар хот,  
 Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
 Утас/Факс: (976) 7012-7042

2022.06.10 № 1/289  
 танай 2022.05.24 ны № 02/0551 -Т

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН**  
**ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН**  
**ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ**  
**ГАЗАРТ**

Цахилгаан болон хийн эх үүсвэрээр ажиллах тээврийн хэрэгслийг цэнэглэх байгууламжийн судалгааг хүргүүлэв.

Судалгааны файлыг [khavi0770@gmail.com](mailto:khavi0770@gmail.com) хаягаар илгээсэн болно.

ЗАХИРАЛ  Б.ГҮРСОРОНЗОН

**Төгсөв.**